

УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМЫН АРБИТРЫН ҮНДСЭН БОЛОН НЭМЭЛТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитр (цаашид “Арбитр” гэх) хянан шийдвэрлэхэд талуудаас төлөх арбитрын зардлын хэмжээг тогтоох, зардлыг төлөхтэй холбоотой журмыг тогтооход оршино.

Хоёрдугаар зүйл. Арбитрын зардал

2.1. Арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэнэ.

2.2. Арбитрчийн хөлс болон арбитрын үйлчилгээний зардалд төлж буй хураамжийг арбитрын үндсэн зардал гэнэ.

2.3. Арбитрт хэрэг шийдвэрлэх тодорхой ажиллагааны явцад гарсан дараахь зардлыг нэмэлт зардалд хамааруулна:

2.3.1. шинжээчийн зардал, ажлын хөлс;

2.3.2. бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийхэд гарсан зардал;

2.3.3. арбитрын ажиллагаа явуулах газартай холбогдон гарсан зардал,

2.3.4. шуудан, хэлмэрч, орчуулагч, гэрчийн зардал, арбитрч, илтгэгч арбитрч болон нарийн бичгийн даргын томилолтын зардал;

2.3.5. арбитрын шийдвэр гүйцэтгэсэн ажлын хөлс;

2.3.6. арбитрын бүрэлдэхүүний удирдамж боловсруулах зардал;

2.3.7. бусад зардал.

2.4. Хэрэв нэхэмжлэлийн үнийг тодорхойлох боломжгүй бол арбитрын үндсэн зардлыг арбитрын ажлын алба тодорхойлно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Арбитрын зардлын хэмжээ

Гуравдугаар зүйл. Арбитрын үндсэн зардлын хэмжээ

3.1. Арбитрын үндсэн зардлыг доорх хувь хэмжээгээр тогтооно:

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөг	Арбитрийн үйлчилгээний зардал/төгрөг	Арбитрчийн хөлс /доод хэмжээ/ төгрөг	Арбитрчийн хөлс /дээд хэмжээ/ төгрөг
50,000,000 хүртэл	3,000,000	500,000	2,500,000
50,000,001- 100,000,000	3,000,000+50,000,000 дээш үнийн дүнгийн 2.9 хувийг нэмнэ.	500,000+50,000,000 дээш үнийн дүнгийн 2.1 хувийг нэмнэ.	2,500,000+50,000,000 дээш үнийн дүнгийн 3.9 хувийг нэмнэ.
100,000,001-200,000,000	4,450,000+100,000,000 дээш үнийн дүнгийн 1.7 хувийг нэмнэ.	1,550,000+100,000,000 дээш үнийн дүнгийн 1.3 хувийг нэмнэ.	4,450,000+ 100,000,000 дээш үнийн дүнгийн 3.2 хувийг нэмнэ.
200,000,001-500,000,000	6,150,000+200,000,000 дээш үнийн дүнгийн 1.3 хувийг нэмнэ.	2,850,000+200,000,000 дээш үнийн дүнгийн 0,9 хувийг нэмнэ.	7,650,000+200,000,000 дээш үнийн дүнгийн 1.4 хувийг нэмнэ.
500,000,001-1,000,000,000	10,050,000+500,000,000 дээш үнийн дүнгийн 0.8 хувийг нэмнэ	5,500,000+500,000,000 дээш үнийн дүнгийн 0.5 хувийг нэмнэ.	11,850,000+500,000,000 дээш үнийн дүнгийн 0.9 хувийг нэмнэ.
1,000,000,001-2,500,000,000	14,050,000+1,000,000,000 дээш үнийн дүнгийн 0.5 хувийг нэмнэ	8,000,000+1,000,000,000 дээш үнийн дүнгийн 0.2 хувийг нэмнэ.	16,350,000+1,000,000,000 дээш үнийн дүнгийн 0.5 хувийг нэмнэ.
2,500,000,001-5,000,000,000	21,550,000+2,500,000,000 дээш үнийн дүнгийн 0.3 хувийг нэмнэ.	11,000,000+2,500,000,000 дээш үнийн дүнгийн 0.1 хувийг нэмнэ.	23,800,000+2,500,000,000 дээш үнийн дүнгийн 0.17 хувийг нэмнэ.
5,000,000,000 дээш	30,000,000	13,500,000+5,000,000,000 дээш үнийн дүнгийн 0.04 хувийг нэмнэ.	28,050,000+5,000,000,000 дээш үнийн дүнгийн 0.09 хувийг нэмнэ.

**Дээрх хүснэгт дэх арбитрчийн хөлс нь нэг арбитчийн хөлс бөгөөд нэгээс илүү арбитрч томилогдсон бол арбитрч бүрээр үржүүлж тооцно.*

3.2. Арбитрчийн хөлсийг тооцож олгохдоо тухайн хэргийг шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа, шуурхай байдал, маргааны онцлог, арбитрын шийдвэр хугацаандаа гарсан эсэх, шүүхийн шийдвэр, үр дүн зэргийг харгалзана.

3.3. Хэрэв талууд тус арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалт дахь арбитрчаас өөр арбитрч сонгон томилуулсан, арбитчийн хөлсийг энэ журмын 3.1-т зааснаас өөрөөр тохиролцсон бол арбитрчийн хөлсний 20 хувьтай тэнцэх хураамжийг арбитрч төлнө.

Дөрөвдүгээр зүйл. Арбитрын нэмэлт зардлын хэмжээ

4.1. Арбитрын нэмэлт зардлын хэмжээг тухайн маргааныг хянан шийдвэрлэхэд холбогдон гарсан энэ журмын 2.3-т заасан зардлын бодит хэмжээгээр тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Арбитрын зардлыг төлөх, буцаан олгох

Тавдугаар зүйл. Арбитрын зардлыг төлөх

- 5.1. Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа арбитрын зардлыг урьдчилан төлсөн байна.
- 5.2. Сөрөг нэхэмжлэл гаргасан тал нэхэмжлэгчийн нэгэн адил арбитрын зардал төлнө.
- 5.3. Нэхэмжлэгч арбитрын зардлыг хэсэгчлэн төлөх талаар арбитрт хүсэлт гаргаж болно. Хэсэгчлэн төлөх зардлын доод хэмжээ арбитрын нийт зардлын 50 хувиас доошгүй байх бөгөөд зардлын үлдэгдлийг арбитрын шийдвэр гарахаас 7-оос доошгүй хоногийн өмнө төлнө.
- 5.4 Нэхэмжлэгчээс арбитрын зардлыг Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын дансанд шилжүүлснээр төлсөнд тооцно.
- 5.5. Нэхэмжлэлийн үнийн дүн гадаад улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд түүнийг нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож арбитрын зардлыг төлнө.
- 5.6. Арбитрт анх нэхэмжлэл гаргахад нэхэмжлэлийн үнийн дүн тодорхой бус тохиолдолд арбитрын үйлчилгээний зардалд 3,000,000 төгрөг урьдчилж төлнө.
- 5.7. Нэхэмжлэлийн үнийг нэхэмжлэгч мөнгөн дүнгээр илэрхийлээгүй тохиолдолд тухайн арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлно.
- 5.8. Зардлыг талууд тус бүр төлөхөөр тодорхойлсон бол ажлын алба өөрийн нэхэмжлэлд ногдох хэсгийг төлөхийг талуудаас шаардаж болно.
- 5.9. Арбитрын ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагын хэмжээ өөрчлөгдсөн, арбитрчийн зардалд өөрчлөлт орсон, арбитрын ажиллагаанд тулгарсан хүндрэл зэргээс шалтгаалан энэ журмын 5.8-д заасан урьдчилгаа төлбөр арбитрын ажиллагааны аль ч үе шатанд өөрчлөгдөж болно.
- 5.10. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэртээ талууд зардлыг хэрхэн төлөх талаар тусгана.
- 5.11. Арбитрын шийдвэр гарсны дараа талууд хэрэгт байгаа нотлох баримт, албан бичиг болон арбитрын шийдвэрийн хуулбарыг авахыг хүсвэл хуудас тутамд 2'000 төгрөг төлнө.

Зургаадугаар зүйл. Арбитрын зардлыг буцаан олгох

6.1. Арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг батлахаас өмнө нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, талууд эвлэрэн хэлэлцсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснээр арбитрын ажиллагааг дуусгавар болгосон бол тухайн арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааны бодит зардлыг тооцон арбитрын төлсөн зардлаас суутган үлдсэн төлбөрийг нэхэмжлэгчид буцаан олгож болно.

6.2. Арбитрын ажиллагааны явцад арбитрын хэлэлцээр хүчингүй болсон, эсхүл тухайн маргаан арбитрын харьяаллын маргаан биш болох нь тогтоогдсон тохиолдолд арбитрын зардлын 50 хувийг нэхэмжлэгчид буцаан олгоно.

6.3. Арбитрын шийдвэр гаргахаас өмнө талууд эвлэрэн хэлэлцэж хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын зардлыг талууд тэнцүү хувиар төлөхөөр арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэж болно.

6.4. Арбитр аль нэг талаас эсхүл талуудаас хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт зардлыг урьдчилан төлүүлэх бөгөөд урьдчилгаа төлбөр нь бодит гарсан зардлаас илүү гарсан тохиолдолд арбитрын шийдвэр гарсны дараа илүү төлбөрийг буцаан олгоно.

6.5. Буцаан олгох төлбөрт хүү тооцохгүй.

6.6. Арбитрын зардлыг энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд буцаан олгохгүй.

Долоодугаар зүйл. Арбитрын ажиллагаатай холбоотой бусад зардал

7.1. Аль нэг талын сонгосон арбитрч арбитрын ажиллагаа явуулах газарт байнга оршин суудаггүй тохиолдолд түүний арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зардлыг тухайн арбитрчийг сонгосон тал төлнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад

Наймдугаар зүйл. Арбитрын зардлын талаарх талуудын эрх хэмжээ

8.1. Аль нэг тал арбитрын ажиллагаатай холбогдон өөрөөс гарсан нэмэлт зардлыг буруутай талаас нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр энэхүү журамд заасны дагуу арбитрын зардлыг төлнө.

8.2. Аль нэг талын хүсэлтээр арбитрын хуралдаанд орчуулга хийх, баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг хүсэлт гаргасан тал төлнө. Арбитрын бүрэлдэхүүний санаачилгаар баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө. Хэрэв талууд харилцан тохиролцон хуралдааныг Монгол хэлээс өөр хэлээр явуулахаар бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.

8.3. Аль нэг талын хүсэлтээр шинжээч томилох бол шинжээчийн зардлыг хүсэлт гаргасан тал, арбитрын бүрэлдэхүүний санаачилгаар шинжээч томилох бол шинжээчийн зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.

Есдүгээр зүйл. Бусад харилцаа

9.1. Арбитрын зардалтай холбогдох энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг арбитрын дарга шийдвэрлэнэ.

Аравдугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

10.1. Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.